

донтуулах сэтгэцтэй нөлөөт бодисыг улсын хилээр гаргахыг завдсан үйлдлийг таслан зогсоосон.

#### Эрэлч нохойн сургалт:

ГЕГ-ын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийн 1993, 1995, 1997, 1999, 2001, 2003, 2005, 2007, 2009, 2012, 2014 онуудад албаны эрэлч нохойн нэгдсэн сургалтыг амжилтай зохион байгуулсан.

1993 оноос 2003 оныг хүртлэх хугацаанд бид архи, спирт, арьс, мал амьтны гаралтай түүхий эдийг олж илрүүлэх чиглэлээр албаны эрэлч нохойг бэлтгэж байсан бол 2003 оноос өнөөг хүртэлх хугацаанд бид “Хар тамхи, мансууруулах сэтгэцтэй нөлөөт бодис”, “Тэсэрч дэлбэрэх бодис”-ыг олж ирүүлэхэд гол чиглэлээ болгон ажиллаж байна.



Олон улсын стандартад нийцүүлэн өөрийн орны онцлогт тохицуулан боловсруулсан Албаны эрэлч нохойг сургах “Анхан шат (онолын 40 цаг, практик дадлага олгох 120 цаг, нийт 160 цаг буюу ажлын 20 хоногийн сургалтын хөтөлбөртэй)”, “Дунд шат (онолын 30 цаг, практик дадлага олгох 210 цаг, нийт 240 цаг буюу ажлын 30 хоногийн сургалтын хөтөлбөртэй)” болон “Мэргшүүлэх шат (дөрвөн төрлийн сургалтын хөтөлбөртэй, үүнд:

1.Бүсчилсэн сургалт; 2.Захиалгат сургалт; 3.Ажлын байрны сургалт; 4.Нэгдсэн сургалт;

#### Хамтын ажиллагаа:

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ, БНХАУ, Казакстан, Азарбайжан, Япон, ХБНГУ зэрэг улстай хамтран сургалт зохион байгуулах, сургалтын орчин, сургалтын хөтөлбөрийг олон улсын албаны эрэлч нохойн сургалтын стандартад нийцүүлэх, хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Мөн БНСУ-ын Эрэлч нохойн сургалтын төвтэй хамтран туршлага судлах, албаны эрэлч нохойн



5

сургалтын болон нохойн үргжийн талаар мэдээлэл солилцох зэрэг асуудлаар хамтран ажиллаж байна.

#### Гадаад сургалт:

Гаалийн өрөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төв нь нийт боловсон хүчний 30 гаруй хувь нь гадаад улс оронд албаны эрэлч нохойг сургах, ашиглах чиглэлээр сургалтанд хамрагдсан. Мөн ОХУ, Азербайжан, Казакстан, Унгар, Япон, БНСУ зэрэг улсын гаалийн эрэлч нохойн албатай туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг дээшлүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна.

#### Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:

Гаалийн өрөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төв нь Хар тамхи, мансууруулах бодис болон сэтгэц нөлөөт эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй тэмцэх, Олон нийтэд хар тамхи мансууруулах бодисийн хор хөнөөлийг таниулах, хар тамхи, мансууруулах бодисыг гаалийн албаны эрэлч нохой хэрхэн илрүүлдэг чиглэлээр илтгэн тавьж, сурталчлан таниулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

#### ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчилүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүслэг, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийр хангах, сан бурдлуулэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дун шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөн шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөгөөнөөгөх, сургалтлагaa хийх болон гаалийн зөрчлюөс үрүүцилан сэргийтэх арга хэмжээг аяч хэрэжүүлж байна.



#### Хаяг:

Сүхбаатар дүүрэг, “Их тойруу-81/1”,  
Улаанбаатар-14193, Монгол Улс  
Утас: (976-11) - 350049  
Факс: (976-11) - 350048  
E-mail: info@customs.mn  
Интернет: <http://www.customs.gov.mn>



МОНГОЛ УЛСЫН  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## ГЕГ-ЫН ДЭРГЭДЭХ ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТЫН ТӨВ



УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН

6



**ГЕГ-ЫН ДЭРГЭДЭХ  
Эрэлч нохойн сургалтын төв**

Эрэлч нохойн сургалтын төвийг байгуулах саналыг анх 1992 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ГЕГ-ын даргын 170 дугаар тушаалаар баталж, албаны эрэлч нохойн сургалтыг анхлан зохион байгуулж, 1993 онд албаны дарга, нэг сургагч, долоон сонсогчтой үйл ажиллагаагаа эхэлж байсан.

**Гаалийн албаны эрэлч нохойн гүйцэтгэх үндсэн үүрэг** нь Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа, бүтээгдэхүүн, мал амьтны гаралтай түүхий эд, хар тамхи, мансууруулах сэтгэцтэй нөлөөт бодис болон тэсэрч дэлбэрэх бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх аливаа үйлдлийг таслан зогсоо, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

**Хүчин чадал:** Гаалийн харьяа 13 газар, хороодод 18 Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байна.

Эрэлч нохой хариуцсан Гаалийн улсын байцаагч нарын 60 гаруй хувь нь хамтын ажиллагаатай гадаад улс орнуудад албаны эрэлч нохойг сургах, ашиглах чиглэлээр сургалтанд хамрагдсан.

Эрэлч нохойн сургалтын төв нь албаны эрэлч нохойн чадавхийг бэхжүүлэх зорилгоор хамтын ажиллагаатай гадаадын улсаас албаны эрэлч нохойг импортоор авахаас гадна дотооддоо үргжлийн хотөлбөрийг зохион байгуулах замаар Гаалийн албаны эрэлч нохойн нохон хангалтыг хийж гүйцэтгэж байна.

**Ашиглаж буй нохойн үүлдэр:**



Овчарка – 12

Лабрадори – 7

Спаниель - 2


Малинуа – 7

Голденретридер – 1

**Ажилласан жилийн дундаж- 4.8**

ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нар 2018 онд гаалийн хяналт, шалгалтыг гүйцэтгэх явцад ангийн гаралтай түүхий эд, химийн бодис, согтууруулах ундаа, сум, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, хар тамхи, мансууруулах сэтгэцтэй нөлөөт бодис зэргийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан эрүүгийн шинжтэй 6, захиргааны шинжтэй 91 үйлдлийг илрүүлэн таслан зогсоож холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн өгсөн.


**МУГЕГ-ЫН ХАРЬЯА ГАЗАР, ХОРООДОД ГААЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТАНД АШИГЛАЖ БУЙ ЭРЭЛЧ НОХДЫН БАЙРШИЛ, 2018 ОН**



**Албаны эрэлч нохойгоор илрүүлсэн зөрчил:**

**2014 онд:** 29402 ширхэг сум болон 5 ширхэг хийн гар бууг хураан авч, улсын орлогото болгосон.

**2016 онд:** Буянт-Ухаа ГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ нь Зорчигчийн ачаанд албаны эрэлч нохойг ашиглан гаалийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэхэд гашиш болон мөс /ice/ тус бүр 33 граммыг илэрсэн.



**2017 онд:** Буянт-Ухаа ГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ нь өөрийн Зик дуудлагатай эрэлч нохойн хамтаар үр чадвар гарган, Швейцар улсаас ирсэн Монгол улсын иргэнээс 6 грамм кетамин болон 30 грамм каннабисын төрлийн ургамлыг хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг газар дээр нь таслан зогсоосон.

**2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр:** Шивээхүрэн ГГ-ын Эрэлч нохой хариуцсан ГУБ нь алекс дуудлагатай эрэлч нохойн хамтаар Монгол улсын иргэн өөрийн фургон маркын автомашиныг нуувч болгон ашиглан улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон 10 грамм Мими гэх кафейн буюу сэргээш агуулсан,